



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/157

Номгон

Төрийн болон байгууллагын архивын баримтын
цахимжуулалтад 2025-2029 онуудад баримтлах
бодлого чиглэл батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1 дүгээр заалт, Хууль зүй дотоод хэргийн сайдын 2023 оны 01 дүгээр сарын 13-ны А/13 дугаар тушаалаар батлагдсан "Цахим архив, албан хэрэг хөтлөлтийн талаар баримтлах чиглэл"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Төрийн болон байгууллагын архивын баримтын цахимжуулалтад 2025-2029 онуудад баримтлах бодлого, чиглэл"-ийг хавсралтаар баталсугай.

2.Бодлого чиглэлийг үр дүнтэй зохион байгуулан арга зүйгээр хангаж ажиллахыг Төрийн архивын тасаг (В.Эрдэнэчимэг)-т, хэрэгжүүлж ажиллахыг нийт байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



Аймгийн Засаг даргын 24-ний өдрийн захирамжийн хавсралт дугаар



**“ТӨРИЙН БОЛОН БАЙГУУЛЛАГЫН АРХИВЫН БАРИМТЫН ЦАХИМЖУУЛАЛТАД
2025-2029 ОНУУДАД БАРИМТЛАХ БОДЛОГО, ЧИГЛЭЛ**

Д/д	З/д	Хэрэгжүүлэх он	Төсөв	Шалгуур үзүүлэлт, хийх ажил	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хариуцах байгууллага ажилтнууд	Хүрэх үр дүн
1	2	3	4	5	6	7	8	9
Нэг.Төрийн архивын сан дахь архивын баримтыг скайнердан ашиглалтын болон нөөц хувь үүсгэх, програмд холболт хийх, дуудалтад бэлтгэх, хянуулж хүлээлцэх, бааз хуулуулах								
1	1.1	2025 он	Улсын болон орон нутгийн төсөв	Тухайн жилийн төлөвлөлтийн тоогоор	80	82	Цахим сангийн ажлын хэсэг	Баримтыг цахим санд шилжүүлэн ашиглалтын болон нөөц хувь бэлтгэж ашиглалтаас чөлөөлж дуудалтад бүрэн бэлтгэсэн байна.
2	1.2	2026 он	Улсын болон орон нутгийн төсөв	Тухайн жилийн төлөвлөлтийн тоогоор	82	84	Цахим сангийн ажлын хэсэг	
3	1.3	2027 он	Улсын болон орон нутгийн төсөв	Тухайн жилийн төлөвлөлтийн тоогоор	84	86	Цахим сангийн ажлын хэсэг	
4	1.4	2028 он	Улсын болон орон нутгийн төсөв	Тухайн жилийн төлөвлөлтийн тоогоор	86	88	Цахим сангийн ажлын хэсэг	
5	1.5	2029 он	Улсын болон орон нутгийн төсөв	Тухайн жилийн төлөвлөлтийн тоогоор	88	90	Цахим сангийн ажлын хэсэг	
Хоёр.Байгууллагын архивын баримтыг скайнердан ашиглалтын болон нөөц хувь үүсгэх, програмд холболт хийх, хянуулж Төрийн архивын санд хүлээлцэх, бааз хуулуулах								
6	2.1	2025 он	Байгууллагын төсөв	Архивын 2022 оны баримтыг цаг хугацаанд нь бүрэн цахим болон цаасан хуваир Төрийн архивд шилжүүлсэн байна.	0	100	Тухайн сан үүсгэгч байгууллагын ажилтнууд	

1	2	3	4	5	6	7	8	9
7	2.2	2026 он	Байгууллагын төсөв	Архивын 2023 оны баримтыг цаг хугацаанд нь бүрэн цахим болон цаасан хуваир Төрийн архивд шилжүүлсэн байна.	0	100	Тухайн сан үүсгэгч байгууллагын ажилтнууд	Тухайн оны байнга хадгалах баримтыг Төрийн архивд цаасан болон цахим хувьтай програмд оруулан дансны хамт цаг хугацаанд нь бүрэн шилжүүлсэн байна.
8	2.3	2027 он	Байгууллагын төсөв	Архивын 2024 оны баримтыг цаг хугацаанд нь бүрэн цахим болон цаасан хуваир Төрийн архивд шилжүүлсэн байна.	0	100	Тухайн сан үүсгэгч байгууллагын ажилтнууд	
9	2.4	2028 он	Байгууллагын төсөв	Архивын 2025 оны баримтыг цаг хугацаанд нь бүрэн цахим болон цаасан хуваир Төрийн архивд шилжүүлсэн байна.	0	100	Тухайн сан үүсгэгч байгууллагын ажилтнууд	
10	2.5	2029 он	Байгууллагын төсөв	Архивын 2026 оны баримтыг цаг хугацаанд нь бүрэн цахим болон цаасан хуваир Төрийн архивд шилжүүлсэн байна.	0	100	Тухайн сан үүсгэгч байгууллагын ажилтнууд	

.....ОоО.....